

## ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

20... оны ... сарын ....

№

Улаанбаатар хот

Энэхүү “Хамтран ажиллах” гэрээг /цаашид “Гэрээ” гэх/ нэг талаас “...” ХХК /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ түүнийг төлөөлж Борлуулалт, Маркетинг хариуцсан захирал нөгөө талаас “.....” ХК /цаашид “Захиалагч” гэх/ түүнийг төлөөлж ..... албан тушаалтай .....овогтой ..... нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ Монгол улсын Иргэний хууль, Зар сурталчилгааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь Захиалагч талын бизнесийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээ мэдээлэл, зар сурталчилгааг Хавсралт №1 заасан телевизүүдийн эфирээр байршуулах ажлыг Захиалагч талаас ирүүлсэн зар сурталчилгаа, мэдээ мэдээллийн дуу дүрсний чанар шаардлагыг алдагдуулахгүйгээр хуулан бэлтгэж /тохиролцсон цагаар/, техникийн өндөр түвшинд цацах, түүнтэй холбогдсон төлбөр тооцооны асуудлыг зохицуулна.
- 1.2. Гүйцэтгэгч тал мэдээ мэдээлэл, сурталчилгаа бүрт гэрээний Хавсралт №1-д заасан үнээр гэрээт ажлыг гүйцэтгэнэ.
- 1.3. Захиалагч тал гэрээт ажлын захиалга өгөхдөө тухай бүр албан тоот болон бусад анхан шатны маягтаар баталгаажуулан хүргэх бөгөөд энэ нь захиалга өгснийг нотлох албан ёсны баримт болно.
- 1.4. **Гэрээний бүрдэл** Дараахи бичиг баримтууд нь гэрээний салшгүй хэсэг байна. Үүнд :
  - 1.4.1. Захиалагч ба Гүйцэтгэгч талын хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар;
  - 1.4.2. Захиалагч ба Гүйцэтгэгч талыг төлөөлж байгуулж буй албан тушаалтны иргэний үнэмлэхний хуулбар;
  - 1.4.3. Үнийн санал;
  - 1.4.4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт орсон бол тухайн гэрээ, хавсаргасан баримтууд.
- 1.5. ....

### Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1. Гэрээний хугацаа нь ..... оны .... сарын ....-ны өдрөөс .... оны ... сарын ...-ны өдөр хүртэл 1 /нэг/ жилийн хугацаатай байна.
- 2.2. ....

### Гурав. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

- 3.1. Реклам сурталчилгаа. мэдээ мэдээллийг нэвтрүүлэх үнийн тарифыг *Хавсралт №1*-д заасан хөнгөлөлттэй үнийн дүнгээр тооцно.
- 3.2. Тухайн сард нэвтрүүлсэн мэдээ мэдээлэл, зар сурталчилгааны гүйцэтгэлийг сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 05-ны дотор тооцоо нийлэх бөгөөд тус хугацаанд тооцоо нийлээгүй тохиолдолд гүйцэтгэлийн дагуу нэхэмжилсэн дүнгээр Захиалагч төлбөрийг талд төлнө.
- 3.3. ....

### Дөрөв. Захиалга өгөх

- 4.1. Захиалагч нь бэлэн нэвтрүүлэг цацах тохиолдолд эфирт цацагдахаас 7 хоногийн өмнө мэдэгдэж цаг аван хөтөлбөрт оруулж, бэлэн болсон нэвтрүүлгээ эфирт зарлагдсан өдрөөс 1 /нэг/ хоногийн өмнө эцсийн байдлаар, HD форматаар эд хүлээлгэн өгөх үүрэгтэй.

- 4.2. Гүйцэтгэгч захиалгыг хүлээн авсан тохиолдолд эфирийн цаг, хөтөлбөрийн хугацааг захиалга хүлээн авсан даруйдаа буюу боломжит хугацааны /ажлын 2 хоног/ дараа Захиалагч талд хариу мэдэгдэнэ.

**Тав. Захиалагч талын эрх, үүрэг**

- 5.1. Гүйцэтгэгч талаас зөвшөөрч талууд хоорондоо тохиролцсон өдөр, цаг, минутын дагуу гүйцэтгэлийг шаардах эрхтэй.
- 5.2. Захиалагч тал нь эфирээр цацагдсан бүх зар сурталчилгааны тайланг бичгээр гүйцэтгэгчээс хүлээн авах эрхтэй бөгөөд хэрвээ эфирт цацсан зар сурталчилгааны тайланг бүрэн бус, эсвэл буруу байна гэж үзвэл уг алдааны талаар тодорхой дурдсан гомдлыг Гүйцэтгэгч талд бичгээр ирүүлж, нөхөлт хийлгэх хүсэлт гаргах эрхтэй.
- 5.3. ....

**Зургаа. Гүйцэтгэгч талын эрх, үүрэг**

- 6.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Захиалагчаас шаардах эрхтэй.
- 6.2 Захиалагчийг үйлчилгээний төлбөр, алданги болон Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс үүдэн гарсан хохирлоо бүрэн барагдуулах хүртэл зар сурталчилгааг нэвтрүүлэхээс татгалзах эрхтэй.
- 6.3 Гүйцэтгэгч тал нь Захиалагч талын бизнесийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээ болон Захиалагчийн нэр хүндэд нөлөөлөхгүй мэдээ мэдээллийг техникийн болон бусад шаардлага хангасан түвшинд захиалсан хуваарийн дагуу цаг хугацаанд нь нэвтрүүлэх, байршуулах үүрэгтэй.
- 6.4 Гүйцэтгэгч тал нь захиалагчийн өгсөн хуваарьт цагт реклам зар сурталчилгааг гэрээгээр тохирсон хугацаанд цацах үүрэгтэй.
- 6.5. ....

*.... Үргэлжлэл бий ...7х*